



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2009 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 141

Сүхбаатар

ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.6, Засгийн газрын "Төрийн албаны тухай сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр батлах тухай" 1999 оны 96 дугаар тогтоолыг үндэслэн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. "Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар" хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, санхүүгийн эх үүсвэр, тооцоо судалгааг нарийвчлан гаргаж жил бүрийн төсөвтөө тусган шийдвэрлэж байхыг төр, төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдэд даалгасугай.



Ж.САНЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2009 оны 14 сарын 10-ний  
Эдрийн 41 тоот тогтоолын хавсралт

## "ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН МЭДЛЭГ ЧАДВАР" ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

### 1.1 Хөтөлбөрийн үндэслэл, зориулалт:

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Моу гол Улсын Засгийн газрын 1999 оны 96-р тогтоолоор батлагдсан "Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох" хөтөлбөр, Сэлэнгэ аймгийн хөгжлийн /2007-2021/ хөтөлбөр, аймгийн Засаг даргын Тамгын газрын стратеги төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэв. Хөтөлбөрийг боловсруулахдаа аймгийн хэмжээний төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээ, түүнийг хангахад чиглэсэн, сургалтын судалгааны үр дүнд тулгуурласан болно.

### Өнөөгийн байдал

Аймгийн төр төсвийн байгууллагуудад нийт 3889 төрийн албан хаагч, үүнээс улс төрийн албан хаагч 103, төрийн захиргааны албан хаагч 341, төрийн тусгай албан хаагч 603, төрийн үйлчилгээний албан хаагч 2842 ажиллаж байна. Нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын 1175 буюу 30.2 хувь нь эрэгтэй, 2714 буюу 69.8 хувь нь эмэгтэй албан хаагч байна.

Боловсролын хувьд салбарын доктор-1, магистр-52, бакалавр-950, дипломын дээд зэрэгтэй-768, тусгай дунд-915, бүрэн дунд-847, суурь боловсролтой-335, бага боловсролтой- 18, боловсролгүй -3 хүн байна.

Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлж, төрийн албанд мэргэшүүлэх үйл явцыг бүх нийтээр ойлгох, зохион байгуулах, дэмжихэд ашиглана.

### 1.2 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага:

Төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлтийн өнөөгийн чиг хандлага нь мэдлэг чадвартай мэргэшсэн төрийн албан хаагчдаар иргэдэд чанар, өгөөжтэй төрийн үйлчилгээг үзүүлэх шаардлага, хариуцлагын шинэ тогтолцоог бий болгосон. Энэ нь төрийн албан хаагчдаас өргөн цар хүрээтэй, шинэлэг мэдлэг ур чадварыг шаарда: байна.

Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг аймгийн хэмжээнд явуулсан бөгөөд үүнд хамрагдсан нийт 2575 албан хаагчдаас 1884 буюу 73 хувь нь мэргэжлийн чиглэлээр давтан сурах, удирдлагын академи, салбарын магистрантур, докторантур, компьютер, англи хэлний чиглэлээр суралцах хэрэгцээ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2009 оны Асарын 10-ний  
Өдрийн 41 тоот тогтоолын хавсралт

**"ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН МЭДЛЭГ ЧАДВАР"  
ХӨТӨЛБӨР**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

**1.1 Хөтөлбөрийн үндэслэл, зориулалт:**

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 96-р тогтоолоор батлагдсан "Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох" хөтөлбөр, Сэлэнгэ аймгийн хөгжлийн /2007-2021/ хөтөлбөр, аймгийн Засаг даргын Тамгын газрын стратеги төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэв. Хөтөлбөрийг боловсруулахдаа аймгийн хэмжээний төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээ, түүнийг хангахад чиглэсэн, сургалтын судалгааны үр дүнд тулгуурласан болно.

**Өнөөгийн байдал**

Аймгийн төр төсвийн байгууллагуудад нийт 3889 төрийн албан хаагч, үүнээс улс төрийн албан хаагч 103, төрийн захиргааны албан хаагч 341, төрийн тусгай албан хаагч 603, төрийн үйлчилгээний албан хаагч 2842 ажиллаж байна. Нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын 1175 буюу 30.2 хувь нь эрэгтэй, 2714 буюу 69.8 хувь нь эмэгтэй албан хаагч байна.

Боловсролын хувьд салбарын доктор-1, магистр-52, бакалавр-950, дипломын дээд зэрэгтэй-768, тусгай дунд-915, бүрэн дунд-847, суурь боловсролтой-335, бага боловсролтой- 18, боловсролгүй -3 хүн байна.

Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлж, төрийн албанд мэргэшүүлэх үйл явцыг бүх нийтээр ойлгох, зохион байгуулах, дэмжихэд ашиглана.

**1.2 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага:**

Төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлтийн өнөөгийн чиг хандлага нь мэдлэг чадвартай мэргэшсэн төрийн албан хаагчдаар иргэдэд чанар, өгөөжтэй төрийн үйлчилгээг үзүүлэх шаардлага, хариуцлагын шинэ тогтолцоог бий болгосон. Энэ нь төрийн албан хаагчдаас өргөн цар хүрээтэй, шинэлэг мэдлэг ур чадварыг шаардаг байна.

Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг аймгийн хэмжээнд явуулсан бөгөөд үүнд хамрагдсан нийт 2575 албан хаагчдаас 1884 буюу 73 хувь нь мэргэжлийн чиглэлээр давтан сурах, удирдлагын академи, салбарын магистрантур, докторантур, компьютер, англи хэлний чиглэлээр суралцах хэрэгцээ

2.2.3.4 Ажилтнуудын мэргэшил, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтанд хамруулах

**2.2.4 Үйл ажиллагааны чадавхи сайтай төрийн алба бүрдүүлнэ.**

*Үйл ажиллагааны чиглэл*

2.2.4.1 Сургалтанд дэмжлэг болохуйц хэрэгцээтэй арга техник, технологийг нэвтрүүлэх

2.2.4.2 Албан хаагч хувийн болон байгууллагын зардлаар суралцах, мэргэжлээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

2.2.4.3 Албан хаагчдыг дотоодын болон бусад улс оронд магистр, докторын зэрэг олгох тэтгэлэгт сургалтанд хамруулах

2.2.4.4 Мэдлэг, ур чадвар сайтай, бусдад үлгэр дууриалалтай албан хаагчдыг дэмжих, урамшуулах

2.2.4.5 Албан хаагчдыг төрийн албаны чиг үүрэгтэй холбогдолтой хэвлэл,

мэдээллийн эх сурвалжаар хангах

**2.2.5 Төрийн албан хаагчийн соёлтой, ёс зүйтэй байх манлайллыг дээшлүүлнэ.**

2.2.5.1 Төрийн байгууллага нь нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллах итгэл даасан байгууллага байж, төрийн албан хаагчид үнэнч шударга ажиллах

2.2.5.2 Албан хаагчид өөрийн үүргээ хуулийн хүрээнд үр дүнтэй, үр ашигтай гүйцэтгэх

2.2.5.3 Иргэдтэй алагчлалгүй харьцах, харилцааны ёс зүйг эрхэмлэх

**2.2.6 Сургалтын зардал, санхүүжилтийн зохистой бодлогыг баримтлана.**

*Үйл ажиллагааны чиглэл*

2.2.6.1 Албан хаагчдын сургалтыг улсын болон байгууллагын зардлаар санхүүжүүлэх

2.2.6.2 Албан хаагчийг хувийн зардлаар суралцахад дэмжлэг үзүүлэх

2.2.6.3 Албан хаагчдыг давтан сургах, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэхэд зарцуулагдах хөрөнгийг байгууллагынхаа тухайн жилийн төсвийн 5 хүртэл хувийг тусгаж хэрэгжүүлнэ.

**2.3 Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

**2.3.1 Төрийн албаны чадавхийг дээшлүүлэх**

2.3.1.1 Төрийн бодлогыг хэрэгжүүлэх, иргэдэд үр өгөөжтэй үйлчилгээг хүргэх чадамжтай алба бүрдүүлэх.

2.3.1.2 Албан хаагчийн ёс зүйн хариуцлагыг өндөржүүлж иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх.

### **2.3.2 Мэргэшсэн албан хаагчдын баг бүрдүүлэх**

- 2.3.2.1 Төрийн зорилт, чиг үүргийг мэдлэг, чадвартай албан хаагчдаар гүйцэтгүүлэх. Мэдлэг чадвартай албан хаагч нь байгууллагын үйл ажиллагааны чадамжийг дээшлүүлэхд чухал үүрэгтэй.
- 2.3.2.2 Цаг үеийн эрэлтэд нийцсэн сургалтын хэрэгцээнд тулгуурлан албан хаагч нь мэдлэг чадвараа дээшлүүлэх.
- 2.3.2.3 Албан хаагчийг ажлын байранд нь мэргэшүүлэх.
- 2.3.2.4 Албан хаагчдыг төрөлжсөн багийн сургалтанд хамруулах.

### **2.3.3 Байгууллага бүр суралцагч байх**

- 2.3.3.1 Албан хаагчийн байгууллагын хөгжлийг хангахад чиглэгдсэн шинэлэг санал, санаачлагыг дэмжих.
- 2.3.3.2 Байгууллагын оюуны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар албан хаагч бүрийн мэдлэг чадварыг хөгжүүлнэ.
- 2.3.3.3 Мэдлэгт суурилсан чадвар, чадамжийг бүрэн ашиглаж мэдлэгийн хүрээг өргөжүүлэх

### **2.3.4 Оролцооны түвшин хүртээмжтэй, тэгш хангагдах**

- 2.3.4.1 Байгууллагын удирдлага нь суралцах хэлбэрийг бүх талаар дэмжиж, шаардагдах боломжит нөхцлийг бүрдүүлэх.
- 2.3.4.2 Албан хаагчийн суралцах идэвхийг өрнүүлэх замаар хариуцлагыг өндөржүүлэх.
- 2.3.4.3 Байгууллагын хэрэгцээнд тохирсон бүтээгдэхүүн нийлүүлэхүйц ур чадвартай хамт олныг нөхөн бүрдүүлэх.

### **2.3.5 Мэдлэг чадварыг нэмэгдүүлэх**

- 2.3.5.1 Өдөр тутмын үйл ажиллагаанд мэдлэг чадварыг чухалчлах.
- 2.3.5.2 Мэргэжлийн сургалтын байгууллага болох Удирдлагын академи, Улсын болон хувийн их дээд сургууль, коллеж, төсөл хөтөлбөрийн боломжит бүх нөөцийг ашиглах.
- 2.3.5.3 Албан хаагчдын ажлын чиг үүргийн онцлогийг харгалзан сургалтыг үр өгөөжтэй хэлбэрээр зохион байгуулах.
- 2.3.5.4 Сургалт нь сэтгэл ханамжийн болон эдийн засгийн урамшилтай байх.

### **2.3.6 Ажлын байранд суралцах боломжийг бүрдүүлэх**

- 2.3.6.1 Албан хаагч бүрийн дадлага, туршлагын давуу талаас харилцан суралцах.
- 2.3.6.2 Хамт олон мэдээлэл солилцох, түүнчлэн шинэ санаа, шийдэлд хүрэхэд цаг хугацааны боломжоор хангагдах.
- 2.3.6.3 Туршлагжсан албан хаагчдыг ажлын байр сэлгэн ажиллуулах замаар чадварыг нь өргөжүүлэх.

### **2.3.7 Төрийн захиргааны албан хаагчдын сургалтын чанар хүртээмжийг бататгах**

2.3.7.1 Сургалт нь эрэлт хэрэгцээнд нийцсэн байх.

2.3.7.2 Сургалтыг зохион байгуулахад дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзэх:

а.Шинээр томилогдсон ажилтнуудад ажлын байрны чиг үүргийг таниулах

б.Бие хүний ур чадварыг дээшлүүлэх

в.Ажлын байранд суралцах

г.Өөрийгөө хөгжүүлэх сургалт

д.Давтан мэргэшүүлэх /богино, дунд хугацааны/

е.Зайны төрөлжсөн сургалт

ё.Багаар ажиллах чадварт суралцах

ж.Цахим сүлжээний сургалт /online/

2.3.7.3 Сургалтанд дотоодын боломжит нөөцийг ашиглах мөн шинэ мэдлэг чадварын хэрэгцээг гадаадын сургалтаар хангах.

2.3.7.4 Үр дүнтэй суралцах нөхцлийг бүрдүүлэх үүднээс байгууллагын удирдлагын зүгээс суралцагчид боломжит дэмжлэгийг үзүүлэх.

#### **2.4. Хөтөлбөрийн зарчим**

2.4.1. Суралцах нөхцөл, баталгаагаар хангах

2.4.2. Эрх тэгш байдлыг хангах

2.4.3. Ил тод байдлыг хангах

2.4.4. Хариуцлагын тогтолцоог эрхэмлэх

2.4.5. Сонголттой, нээлттэй, тасралтгүй байх

2.4.6. Төрийн захиргааны албан хаагчийн сургалт нь хамрагдагсад болон байгууллагын хэрэгцээнд тулгуурласан байх

2.4.7. Мэргэшсэн тогтвортой байх

#### **Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

Хөтөлбөрийг 2010-2016 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.1-р үе шат /2010-2012/

2.2-р үе шат 2012-2016/

#### **Дөрөв.Хөтөлбөрийн санхүүжилт**

Дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

4.1. Төрийн албан хаагчдын хувийн зардал

4.2. Төвлөрсөн төсвийн хөрөнгө

4.3. Орон нутгийн төсөв

4.4. Олон Улсын хамтын ажиллагааны санхүүжилт

4.5. Бусад эх үүсвэр

### **Тав. Удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ**

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангаж, хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэнэ.

5.2. Хөтөлбөрийг түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бусад холбогдох төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

5.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг нийт төр төсвийн байгууллагуудын менежерийн жил бүрийн үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана.

5.4 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдалд хяналт шинжилгээ үнэлгээ хийж үр дүнг тооцно.

5.5. Байгууллага бүр өөрсдийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

### **Зургаа. Хөтөлбөрийн үр дүн**

6.1. Төрийн албаны шинэтгэлийг орон нутагт хөгжүүлж, төрийн үйлчилгээг илүү хүртээмжтэй болгохын тулд албан хаагчид өндөр үүрэг хариуцлагатай ажиллаж, байгууллагын зорилго, зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд нөлөөлнө.

6.2. Төрийн албан хаагчийн ажлын ачаалал даах, үүрэг хариуцлага хүлээх чадвар нэмэгдэнэ.

6.3. Байгууллага бүрийн сурах, суралцуулах чадамж дээшилнэ.

6.4. Төрийн албаны хүний нөөцийн чадамж ажлын дадлага туршлагатай мэргэшсэн албан хаагчдаар бүрдэж, удирдах ажилтны манлайлал дээшилнэ.

6.5. Сургалтын хэрэгцээгээ төрийн албан хаагч өөрөө, байгууллагын сургалтын хэрэгцээг байгууллагын удирдлага, ажилтан хамтран тодорхойлдог болно.

6.6. Албан хаагчдын мэдлэг чадвар дээшилж, гадаад, дотоод, орчны өөрчлөлт, хэрэгцээ шаардлагад нийцдэг болно.